

Нийгмийн харилцаанд зай барих журмыг өндөржүүлсэн байдалд шилжүүлнэ. (21.12.18.~22.1.2.)

Хувийн уулзалт цуглааны зохицуулалт(бүх орон нутагт 4 хүн хүртэл),үйл ажиллагаа явуулах цагийн зохицуулалт(21цаг,22цаг хязгаарлах), өдөр тутмын амьдралд зай барих журмыг өндөржүүлнэ.

□ Анхаарах зүйлс

○ Хувийн уулзалт цуглаан хийх хүний тоог цөөлөх : 4 хүн хүртэл боломжтой

- Вакцин хамрагдаагүй хүн вакцинд бүрэн хамрагдсан хүмүүстэй хамт үйлчлүүлэх боломжгүй (1 хүн зөвхөн ганцаараа үйлчлүүлэх боломжтой)
- Зөвхөн гэр бүлийн гишүүд, асран хамгаалах(хүүхэд·өндөр настан·хөгжлийн бэрхшээлтэй иргэд) зэрэгт онцгойлон үзэх хүрээг хэвээр үлдээнэ.

○ Үйл ажиллагааны цагийг 21цаг хүртэл хязгаарлана(1бүлэг*, 2бүлэг**)

*1бүлэг : Зугаа цэнгээний газар, **2бүлэг : Хоолны газар, кафе, караоке, усанд орох газар, спорт заал зэрэг

- 3бүлэг***болон бусад зарим нэг байгууламжид 22цаг хүртэл хязгаар тогтооно.

*** дугуйлан, кино театр, концертын танхим, РС, уншлагын танхим зэрэг, бусад зарим нэг байгууламж (уралдааны талбай, хүүхэд саатах кафе, массажны газар зэрэг)

○ Арга хэмжээ·Цуглаан : Томоохон арга хэмжээ· Цуглааны хорио цээрийн дэглэмийг чангатгана.

- Хүний тоо 49 хүртэл вакцинд бүрэн хамрагдсан хамрагдаагүй хамаарахгүйгээр оролцох боломжтой.
- 50аас дээш хүн байх тохиолдолд вакцинд бүрэн хамрагдсан эсэхээр ялган 299хүн хүртэл оролцох боломжтой.

○ Бусад өдөр тутамд ашигладаг салбар

- Сургууль, ажлын байр, төрийн байгууллагууд гэх мэт өдөр тутамд ашиглагддаг салбаруудад зай барих журмыг чангатгана.

• Сургууль : нягтралыг 2/3 түвшинд тохируулах

Бүс нутаг тус бүрд халдварын нөхцөл байдлыг харгалзан үзэж бүс нутаг тус бүрд, сургууль тус бүрд уян хатан зохицуулалт хийх боломжтой.

Бага сургуулийн нягтралыг 5/6, дунд ахлах сургуулийн нягтралыг 2/3 (12/20 эхлэн мөрдөнө)

• Ажлын байр : Гэрээр алсын зайнаас ажиллах журмыг идэвхжүүлэх, зөрүү цагаар ажиллах системийг идэвхтэй ашиглах зэрэг ажлын байран дахь нягтралыг бууруулах.

• Төрийн байгууллага : Уулзалт арга хэмжээний хугацааг сунгах эсвэл цуцлах ба зай барих дэглэмийн өндөржүүлсэн журамд захирагдан цугларах, цайллага хийхийг багасгах мэтчилэн төрийн албаны сахилга батыг чанд сахина уу.